

## НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

### ЭРХ ЗҮЙН АЖЛЫН ТАЙЛАН (2023 оны хагас жилийн байдлаар)

2022 оны 06 дугаар сарын 06

Улаанбаатар хот

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль” тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд газраас гарч буй албан бичиг, тушаал, гэрээний хууль эрх зүйн үндэслэлийг хянах, Худалдан авах ажиллагаанд оролцогч иргэн, аж ахуйн нэгж, хуулийн этгээдэд хууль тогтоомжийн хүрээнд эрх зүйн туслалцаа үзүүлэх, хууль тогтоомжийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар холбогдох дээд шатны байгууллагад санал боловсруулан хүргүүлж шийдвэрлүүлэх, удирдлага болон мэргэжилтэнг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах, аливаа гомдол, маргааныг шийдвэрлэх ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

#### НЭГ. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТАЛААР МЭРГЭЖИЛ, АРГА ЗҮЙН ЗААВАР ЗӨВЛӨГӨӨ ӨГЧ АЖИЛЛАСАН ТАЛААР:

Тус хэлтэст 2023 оны хагас жилийн байдлаар нийт 3 хэрэг маргаан хянан шийдвэрлэгдэж байна. Үүнд:

- захиргааны маргаан 3;

Дээрх хэрэг маргааныг төрлөөр нь авч үзвэл:

- Худалдан авах ажиллагаатай холбоотой 3;

“Юу Эм Ди” ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг:

Нийслэлийн Засаг даргын 2018 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн “Газар эзэмших эрхийг баталгаажуулах тухай” А/1111 дугаар захирамж, 2013 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн А/895 дугаар захирамжийн “Юу Эм Ди” ХХК-д холбогдох хэсгийг хүчингүй болгуулах нэхэмжлэлийн шаардлагатай захиргааны хэрэгт тус газраас 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 4/2348 дугаар албан бичгээр Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Оюун-Эрдэнэ, мэргэжилтэн Б.Пүрэвсүрэн нарыг итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилсон.

2019 оны 06 дугаар сарын 14-ний өдөр шүүхэд дуудан ирүүлэх мэдэгдэх хуудас хүлээж авч, 2019 оны 06 дугаар сарын 20-ны өдөр нэхэмжлэлийг гардан авсан. 2019 оны 06 дугаар сарын 24-ний өдөр хариу тайлбар гаргасан. 2019 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 10.00 цагт хуралдаж Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 128/ШЗ2019/4342 дугаар захирамжаар Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлж, маргаан бүхий газарт хамаарах хэсгийг эцэслэн шийдвэрлэх хүртэл түдгэлзүүлсэн. 2019 оноос хойш нэхэмжлэгч шүүх хуралдаан болгон дээр хүсэлт гаргаж, уг хүсэлтийг шийдвэрлэх ажиллагаа хийгдсэн тул анхан шатны шүүх хуралдаан хуралдаагүй. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 96 дугаар зүйлийн 96.2 дахь хэсэгт заасны дагуу Нэхэмжлэгч хүсэлт гарган Анхан шатны шүүх хуралдаан тодорхой хугацаагаар хойшлогдсон. Анхан шатны шүүх хуралдааны тов 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдөр товлогдсон боловч Сүхбаатар дүүргийн Газар зохион байгуулалтын албанаас хэргийн материалтай танилцах боломж олгохыг хүссэн хүсэлтийн дагуу хойшилж 2023 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 10.00 цаг хүртэл хойшилсон.

“Пи эм” ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг:

НХААГ-ын 2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 3/1702 дугаар “Мэдэгдэл хүргүүлэх тухай” шийдвэрээр мэдэгдсэн тендерийн үнэлгээний хорооны шийдвэрийг бүхэлд нь хүчингүй болгуулах, 2.Монгол улсын сангийн яамны 2022 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 03/6882 тоот “Гомдол хянасан тухай” шийдвэрийн “Пи Эм” ХХК-тай холбогдох хэсгийг хүчингүй болгуулах, 3.НХААГ/202208677 дугаартай Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 150 ор (БЗД, 15-р хороо, 122 дугаар цэцэрлэг) тендерт манай компанийн ирүүлсэн тендерийг “Хамгийн сайн үнэлэгдсэн” тендерт шалгаруулж гэрээ байгуулах эрх олгохыг НХААГ-т даалгах нэхэмжлэлийн шаардлагатай захиргааны хэрэгт тус газраас 2022 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 4/1955 дугаар албан бичгээр Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Оюун-Эрдэнэ, мэргэжилтэн Б.Пүрэвсүрэн нарыг итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилсон.

“Пи эм” ХХК-иас Актын биелэлтийг түдгэлзүүлэх хүсэлт гаргасны дагуу Нийслэл дэх анхан шатны шүүхийн шүүгчийн 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 128/ШЗ2022/9335 дугаар захирамжаар актын биелэлтийг түдгэлзүүлэх хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 4/2045 дугаар албан бичгээр шүүхэд 737 хуудас нотлох баримт хүргүүлсэн. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 128/ШШ2022/00890 дугаар шийдвэрээр нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. ЗХХШТХ-ийн 114 дүгээр зүйлийн 114.1-д заасан хугацаанд давж заалдах гомдол гаргаагүй тул анхан шатны шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон.

“Ситиланд марк” ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг:

НХААГ-ийн 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 3/2264 дугаар шийдвэрээр мэдэгдсэн тендерийн үнэлгээний хорооны шийдвэрийг хүчингүй болгуулах, НХААГ-аас зарласан НХААГ/202208558 дугаар бүхий Сургуулийн барилга, 640 суудал (Улаанбаатар хот Хан-Уул дүүрэг, 18 дугаар хороо)-ийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт “Ситиланд марк” ХХК-ийг шалгаруулж, гэрээ байгуулах эрх олгохыг даалгах нэхэмжлэлийн шаардлагатай захиргааны хэрэгт тус газраас 2023 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 4/126 дугаар албан бичгээр Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Оюун-Эрдэнэ, мэргэжилтэн М.Номин-Эрдэнэ, Төлөвлөлт, худалдан авах ажиллагааны хэлтсийн Ахлах мэргэжилтэн Б.Дөлгөөн нарыг итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилсон.

“Ситиланд марк” ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэргийн анхан шатны шүүх хурал 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 2309 дүгээр захирамжаар Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.1, 54.1.3 дахь заалтыг үндэслэн Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, хэргийг хэрэгсэхгүй болгосон. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 114.1 дэх хэсэгт заасны дагуу давж заалдах гомдол гаргасан.

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хурал 2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр хуралдаж 221/ШТИ2023/0363 шүүхийн тогтоолоор Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.1 дэх хэсэгт заасны дагуу Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон. Тус хуулийн 110 дугаар зүйлийн 110.1.2 дахь заалтад заасны дагуу Давж заалдах шатны шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.7-д заасны дагуу энэхүү шүүхийн тогтоол нь эцсийн байна.

Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-д оруулсан эсэхэд 2023 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн байдлаар хяналт тавьж, тендер шалгаруулалтын үр дүн, гэрээг батлагдсан даруйд цахим системд нийтэлж, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг 3, дүүргийн худалдан авах албад, орон нутгийн өмчит үйлдвэр, бусад нийт 24 байгууллагуудад 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдөр албан бичиг хүргүүлж, дүнг 05 дугаар сарын 29-ний өдөр нэгтгэн авахаар төлөвлөсөн.

Нийслэлийн нутгийн захиргааны 24 байгууллага, давхардсан тоогоор 581 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалт зохион байгуулсан ба тендер шалгаруулалтыг дараах үр дүнтэйгээр цахим системд бүртгэгдсэн байна. Үүнд:

- Үр дүн оруулсан-467;
- Үр дүн оруулаагүй-6;
- Гэрээ оруулсан-0;
- Гэрээ оруулаагүй-275 төсөл, арга хэмжээ байгаагаас үр дүн, гэрээ оруулаагүй 281 төсөл, арга хэмжээ байна.

Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-д 285 төсөл, арга хэмжээний үр дүн, гэрээ ороогүй байснаас Нийслэлийн нутгийн захиргааны 20 байгууллага цахим системд нийт 245 төсөл, арга хэмжээний үр дүн, гэрээг оруулсан бөгөөд хэрэгжилт 85,9%-тай байгааг илгэх хуудсаар Газрын даргад танилцуулсан.

Нийслэлийн Засаг даргын 2023 онд захирамжаар эрх шилжиж ирсэн 32, харьяа байгууллагуудаас албан бичгээр хүсэлтээр ирсэн 52, нийт 84 төсөл, арга хэмжээ, 2022 оноос он дамжсан 59 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. Гэрээ хийгдсэн 77, гэрээ байгуулах зөвлөмж хүргүүлсэн 28, гэрээ байгуулах эрх олгосон 0, тендерийн үнэлгээ хийж байгаа 3, тендерийн материал хүлээн авч байгаа 20, тендерийн баримт бичиг боловсруулж байгаа 10, зураг, төсөв ажлын даалгавар байхгүй 5, захирамжаар хүчингүй болсон 17 төсөл арга хэмжээ байна.

## ХОЁР. ХУУЛЬ ТОГТООМЖ СУРТАЛЧЛАХ, СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛСАН ТАЛААР:

Тус газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр батлагдсан сургалтын төлөвлөгөөний дагуу Мэдээллийн технологийн хэлтсийн дарга Б.Түмэнжаргал “Засгийн газрын худалдан авах ажиллагааны тухай, үнэлгээний хорооны зохион байгуулалт, тендерийн баримт бичиг боловсруулах, цахим систем ашиглалт, авлигын эсрэг хуулийн тухай” сэдэвт 11 удаагийн сургалтыг Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага-22, ОНӨААТҮГ-4, ОНӨТҮГ-5, 8 дүүргийн нийт 39 байгууллагын 225 албан хаагчдад сургалт зохион байгуулсан. Үүнд:

- 2023 оны 01 дүгээр сард ННЗБ, ОНӨААТҮГ, ОНӨТҮГ-т нийт 2 удаагийн сургалтыг 11 байгууллагын 42 албан хаагчдад тус газрын 1012 тоот өрөөнд танхимаар;
- 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдөр 9 байгууллагын 16 албан хаагчдад тус газрын 1012 тоот өрөөнд танхимаар;
- 2023 оны 02 дугаар сарын 08, 09-ний өдөр Багануур дүүргийн ЗДТГ-т 3 байгууллагын 40 албан хаагч (Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газар болон Худалдан авах ажиллагааны албаны нийт 20 албан хаагч, Багануур ХК-ны 10 ажилтан, Багануур зүүн өмнөд бүс цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ний 10 ажилтан)
- 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдөр Сонор плаза 5 давхарт 8 байгууллагын 18 албан хаагчдад;
- 2023 оны 03 дугаар сарын 14-ний өдөр тус газрын 1012 тоот өрөөнд танхимаар 5 дүүргийн 20 албан хаагчдад;
- 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдөр Баянзүрх дүүргийн ЗДТГ-ын байранд 23 албан хаагчдад;
- 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдөр Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ-ын 37 албан хаагчдад;
- 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдөр Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын 29 албан хаагчдад тус тус танхимын сургалтыг зохион байгуулан ажиллалаа.

Газрын даргаас өгсөн үүрэг даалгаврын дагуу Хууль, эрх зүйн хэлтсийн Ахлах мэргэжилтэн Б.Оюун-Эрдэнэ, мэргэжилтэн Б.Отгонсүрэн нар

- 2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр Байгууллагын албан хаагчдад Даатгагчийн баталгааны танилцуулга, Нийслэлийн Засаг даргын А/52 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт Захирамжлалын баримт бичиг гаргах журмын танилцуулга
- 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдөр “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийн танилцуулга сургалт хийсэн.

## ГУРАВ. ХЭЛЭЛЦҮҮЛЭГ, СУРГАЛТАД ОРОЛЦСОН ТАЛААР

Тайлант хугацаанд Төрийн албаны сургуулийн Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 3 албан хаагч өөрсдийн зардлаар, төрийн албан хаагчийн давтан сургалтад 1 албан хаагч квотоор тус тус хамрагдаж байна.

Албан хаагчдын чадавхыг дээшлүүлэх зорилгоор сургалтын хэрэгцээг гүүгл форм үүсгэн тодорхойлж НЗДТГ-ын Хүний нөөцийн хөгжлийн төвд хүргүүлэн квот авснаар уг хөгжлийн төвөөс зохион байгуулсан 8 төрлийн сургалтад давхардсан тоогоор 20 албан хаагчийг хамруулсан.

Төрийн албаны зөвлөлөөс Пүрэв гараг бүр зохион байгуулдаг 7\*4\*10 сургалт 5 удаа тус бүр дунджаар 18 албан хаагчдыг хамруулсан.

Нийслэлийн Онцгой байдлын газраас зохион байгуулсан команд штабын танхимын сургалтад 23, биечлэн дадлага сургалтад 10 албан хаагч тус тус хамрагдсан.

ЦЕГ-ын Хар тамхитай тэмцэх газраас зохион байгуулсан “Анзаар аян”-ы хүрээнд “Мансууруулах бодис сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх” сэдэвт танхимын сургалт,

Мөн байгууллагаас зохион байгуулсан “ISO”, “ХАБЭА”, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх”, “Жендерийн тэгш эрх” сургалт, “Төрийн албан хаагчийн ёс зүй, имиж бүрдүүлэлт” сургалтуудад тус бүр 18-23 албан хаагчид хамрагдсан. Нийт 19 төрлийн сургалтад албан хаагчид давхардсан тоогоор 143 удаа хамрагдсан байна.

## ДӨРӨВ. АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

Монгол Улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан байгууллагын хүлээх нийтлэг үүрэг, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлд заасан нийтлэг үүрэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар төрийн байгууллагын хүлээх нийтлэг үүрэг, албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журмыг хэрэгжүүлэх чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаарх аж аж ахуйн нэгж, байгууллагын нийтлэг үүргийн хүрээнд:

1. Манай газар Нийслэлийн Засаг захиргааны IV байрны 10 дугаар давхарт үйл ажиллагаа явуулдаг бөгөөд гадна орчин нэгдсэн харуул хамгаалалт, камерын системд холбогдсон. Байгууллагын доторх камерын хяналтын системийг иж бүрэн шинэчилсэн.

2. Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх” төлөвлөгөөг боловсруулж 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдөр газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хагас жилийн байдлаар төлөвлөгөөнд тусгагдан 5 арга, хэмжээнээс 2 арга, хэмжээ хэрэгжсэн байна.

Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд:

1. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын 2023 оны төлөвлөгөөг боловсруулан 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн А/06 дугаар тушаалаар тус тус баталж, байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулж олон нийтэд ил тод мэдээлсэн.

2. Монгол Улсын хөгжлийг боомилон сааруулагч гол хүчин зүйлс болох авлига, албан тушаалын гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах нийгэм, эдийн засаг, эрх зүй, зохион байгуулалтын олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлж, авлига, хууль бус үйлдэлтэй үл эвлэрэх, үл тэвчих хандлагыг олон нийтийн дэмжлэг, оролцоотойгоор төлөвшүүлэн бүх шатанд авлигыг таслан зогсоосны үндсэн дээр хүний эрхийг ханган нийтийн эрх ашгийг хамгаалж, хувийн хэвшлийг дэмжин хөгжүүлж, эдийн засгийн үр өгөөжийг сайжруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08 өдрийн 49 дүгээр тогтоолоор 2023-2024 оныг "Авлигатай тэмцэх жил" болгон зарлан Авлигатай тэмцэх таван үйл ажиллагаа (Шүгэл, Шүүр, Шувуу, Шилжүүлэн авах, Шил ажиллагаа)-г хэрэгжүүлж байна.

Шүүр ажиллагааны хүрээнд хууль зөрчин томилогдсон албан хаагчдыг чөлөөлөх тухай хугацаатай албан бичиг 2 байгууллагаас ирүүлсэн ба хариуг хугацаанд нь хүргүүлж ажилласан. Үүнд:

ЗГХЭГ-ын 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн ХЭГ/595 дугаар албан бичгээр ирүүлсэн хариуг 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 2/517 дугаар албан бичгээр, НЗДТГ-аас 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 03/1564 дүгээр албан бичгээр ирүүлсэн хариуг 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 2/505 дугаар албан бичгээр тус тус хууль зөрчин томилогдсон албан хаагч байхгүй талаарх хариуг хүргүүлсэн.

Шил ажиллагааны хүрээнд дараах мэдээллийг байгууллагын UB-PROCUREMENT.MN цахим хуудсанд 35 мэдээ мэдээллийг иргэд, олон нийтэд нээлттэй түгээж ажилласан байна.

Үүнд:

- Ил тод байдал цэсэд хамаарах үйл ажиллагааны ил тод байдал дэд цэсэд 14 мэдээ, хүний нөөцийн ил тод байдал цэсэд 2 мэдээ, авлигын эсрэг цэсэд 5 мэдээ;
- Бидний тухай цэсэд 2 мэдээ;
- Үйлчилгээ цэсэд 5 мэдээ;
- Хууль, эрх зүй цэсэд 3 мэдээ;
- Цаг үеийн байдлаар 4 мэдээ мэдээлэл тус тус нийтэлсэн.

3. Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5. “Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан хүлээн авч Авлигатай тэмцэх газарт хүргүүлнэ.” гэж заасны дагуу хянуулж хэвшсэн. Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох

зорилгоор байгууллагын цахим хуудасны “Ил тод байдал” цэсний “Авлигын эсрэг үйл ажиллагаа” хэсэгт “ХАСУМ хянасан дүгнэлт” цэсэд 4 албан хаагчийн ХАСУМ хянасан дүгнэлтийг ил тод мэдээлэн ажилласан. 1 албан хаагчийн ХАСУМ хянасан дүгнэлтийг хянуулахаар Авлигатай тэмцэх газарт хүргүүлээд байна.

4.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3.”Албан тушаалтан хувийн ашиг сонирхлын мэдүүлгээ тухайн албан тушаалд сонгогдсон буюу томилогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор, цаашид тухайн албан тушаалыг хашиж байгаа хугацаандаа жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргаж, энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасан байгууллага, албан тушаалтанд өгөх үүрэгтэй.” гэж заасны дагуу хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргадаг албан тушаалтнуудаар мэдүүлгийг хуулийн хугацаанд бөглүүлэн авч бүртгэл хөтлөн ажиллаж байна. Тайлант хугацаанд нийт давхардсан тоогоор шинээр томилогдсон, шинэчлэн гаргасан 32 албан хаагчийн ХАСХОМ-ийг хүлээн авч баталгаажуулсан.

5.Нийт алба хаагчдаас Худалдан авах ажиллагаанд оролцож байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөлтэй хувийн харилцаа тогтоохгүй, тэдгээрээс хувийн болон албаны чиглэлээр тусламж дэмжлэг хүсэхгүй байх, мөн Үнэлгээний хороонд ажиллах хугацаандаа бусдаас эдийн бус баялаг, тэдгээрийн өмчлөх эрхийг шилжүүлэхийг, төлбөргүй эсхүл хөнгөлөлттэй үйлчилгээ үзүүлэхийг санал болгосон тохиолдолд энэ талаар хуульд заасны дагуу шууд удирдах албан тушаалтан болон Авлигатай тэмцэх газарт мэдэгдэж ажиллах талаар мэдээлэл өгч, энэ талаар алба хаагчдаас бичгээр баталгаа гаргуулан ажиллаж байна.

6.Байгууллагын цахим хуудасны “Ил тод байдал” цэсний “Авлигын эсрэг үйл ажиллагаа” хэсэгт “Соён гэгээрүүлэх үйл ажиллагаа” цэсийг шинээр нээн хөтөлж байгаа бөгөөд, Ном, гарын авлага, Хэвлэмэл материал, сурталчилгаа, видео мэдээ, Сургалтын слайд танилцуулга цэсүүдэд АТГ-аас гаргасан мэдээллийг 100 хувь байршуулсан.

7.Албан тушаалтан 2023 оны 02 дугаар сарын 15-ны дотор АТГ-ын цахим системд мэдүүлгээ гаргах үүрэгтэй видео мэдээг цахим хуудсанд байршуулан улирал бүр мэдээллийн шинэчлэлт хийж ажиллаж байна.

8. Авлигын эсрэг хууль тогтоомжийн дагуу ЭБАТ-ын үйл ажиллагаанд мөрдөх бүртгэлийн маягтыг Авлигатай тэмцэх газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/31 дүгээр тушаалаар шинэчлэн баталсантай холбогдуулан холбогдох маягтуудыг шинэчилсэн маягтын дагуу бүртгэл үйлдэн ажиллаж байна.

9.НЗДТГ-ын 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 04-02/2423 дугаар албан бичгийн дагуу Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан “Шинээр томилогдсон албан хаагчид болон өмнө авлигын эсрэг сургалтад хамрагдаж байгаагүй албан хаагчдад зориулсан сургалт”-д 2023 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр Хууль эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн Б.Пүрэвсүрэн, Б.Отгонсүрэн, Захиргаа, санхүүгийн хэлтсийн Тогтоол захирамж шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн Г.Ариунзаяа, Мэдээллийн технологийн хэлтийн Сургалт олон нийттэй харилцах мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Отгонжаргал, Төлөвлөлт, худалдан авах ажиллагааны хэлтсийн Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, тайлан хариуцсан мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Наранцацрал нар хамрагдсан.

10.Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын даргын баталсан 2023 оны сургалтын төлөвлөгөөний дагуу 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдрөөс 02 дугаар сарын 10-ны өдрийн хооронд ННЗБ, ОНӨААТҮГ, ОНӨТҮГ-ын албан хаагчдад Засгийн газрын худалдан авах ажиллагааны тухай, үнэлгээний хорооны зохион байгуулалт, тендерийн баримт бичиг боловсруулах, цахим систем ашиглалт, авлигын эсрэг хуулийн тухай сургалтыг зохион байгуулав. Энэхүү сургалтын үеэр 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр Авлигатай тэмцэх газрын комиссар н.Цэдэн-Иш “Авлигын эсрэг хуулийн тухай” мэдээллийг сургалтад оролцогчдод өгч ажилласан. Үүнд:

- Хүнс, хангамж төв ОНӨААТҮГ – 6 албан хаагч;
- Нийслэлийн Архивын газар – 2 албан хаагч;
- Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар - 5 албан хаагч;
- Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар - 4 албан хаагч;
- Нийтлэг үйлчилгээний газар – 8 албан хаагчид тус тус хамрагдсан.

11.Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтлан ажиллаж байгаа бөгөөд 2022 оны 12

дугаар сарын 06-ны өдрийн байдлаар нийт 143 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна. Үүнээс:

- ✓ Гэрээ байгуулах эрх олгосон 0;
- ✓ Гэрээ байгуулах зөвлөмж хүргүүлсэн 28;
- ✓ Гэрээ хийгдсэн 77;
- ✓ Зураг төсөв, ажлын даалгавар байхгүй ажил 5;
- ✓ Тендерийн баримт бичиг боловсруулж байгаа 10;
- ✓ Тендерийн материал хүлээн авч байгаа 20;
- ✓ Тендерийн үнэлгээ хийгдэж байгаа 3 төсөл, арга хэмжээ байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2."Захиалагч тендер шалгаруулалтын тухай дэлгэрэнгүй мэдээллийг ил тод, нээлттэй зарлах бөгөөд сонирхсон этгээдэд саадгүй олгоно." гэж заасны дагуу худалдан авах ажиллагааг 100 хувь Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-ээр зохион байгуулан ажиллаж байгаа бөгөөд оролцогчид цаг, хугацаа, орон зайнаас үл хамааран тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй татаж үздэг.

Тус газарт эрх шилжин ирсэн төсөл, арга хэмжээг тухай бүр нээлттэй ил тод болгож цахимаар хянах орчныг бүрдүүлж, нээлттэй, ил тод болгож мэдээллийг сайжруулан ажилласан байна. Үүнд:

1. [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn), [www.ub-procurement.mn](http://www.ub-procurement.mn) цахим системд хуулийн дагуу тухай бүр нийтэлсэн- 2023 онд нийтэлсэн 80 төсөл, арга хэмжээ, 2022 оны 59 (багц болж задарснаар),
2. Өдөр тутмын сонинд урилга нийтэлсэн - 121 (багц болж задраагүй),
3. "Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар" фэйсбүүк хуудсаар тендерийн нээлтийг шууд дамжуулалт хийсэн-105,
4. [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим системд гэрээ бүртгэсэн-77 төсөл, арга хэмжээ (2022 оны 219 гэрээ)
5. Тус газарт эрх шилжин ирсэн төсөл, арга хэмжээний урилга, үр дүнг тухай бүр [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn), [www.ub-procurement.mn](http://www.ub-procurement.mn) цахим системд нийтэлсэн.

#### ТАВ. ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАСАН ТАЛААР

1. Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын цахим хуудсанд мэдээлэл өгөх хуваарийг 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр газрын даргаар батлуулж хуваарийн дагуу байгууллагын UB-PROCUREMENT.MN цахим хуудсанд 35 мэдээ мэдээллийг иргэд, олон нийтэд нээлттэй түгээж ажилласан байна.

Үүнд:

1. Ил тод байдал цэсэд хамаарах үйл ажиллагааны ил тод байдал дэд цэсэд 14 мэдээ, хүний нөөцийн ил тод байдал цэсэд 2 мэдээ, авлигын эсрэг цэсэд 5 мэдээ;
  2. Бидний тухай цэсэд 2 мэдээ;
  3. Үйлчилгээ цэсэд 5 мэдээ;
  4. Хууль, эрх зүй цэсэд 3 мэдээ;
  5. Цаг үеийн байдлаар 4 мэдээ мэдээлэл
2. 2022 оны жилийн эцсийн байдлаар НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 90 дүгээр тогтоолоор батлагдсан "Нийслэлийн эрх зүйн мэдээллийн нэгдсэн санг эрхлэх хөтлөх журам"-ын хэрэгжилтийг хангаж, мэдээг 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 4/2370, 2023 оны I улирлын байдлаар 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 4/548 дугаар албан бичгээр тус тус хүргүүлэн ажилласан. 2023 оны хагас жилийн байдлаар 07 дугаар сарын 05-ны өдөр тайлагнахаар төлөвлөн ажиллаж байна.
- Нийслэлийн эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан ([ublegal.ulaanbaatar.mn](http://ublegal.ulaanbaatar.mn))-д
- 2023 оны А тушаал 41, Б тушаал 38 оруулан хяналт тавьж ажилласан.
3. Нийслэлийн Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/567 дугаар захирамжаар батлагдсан "Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн ажиллах журам"-ын дагуу Шүүхийн мэдээ, шүүх хуралдааны товыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэст холбогдох цахим хаягаар 7 хоногийн 5 дахь өдөр болгон мэдээ, тайлан 19 удаа хүргүүлэн ажиллаж байна.
4. 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 4/1059 дүгээр албан бичгээр Шүүхэд төлөөлсөн байдал, хянан шийдвэрлэгдэж буй хэрэг маргааны тайлан гаргаж хүргүүлсэн.

5.Газрын даргын 2022 оны А/16 дугаар тушаал, 2023 оны А/01 дүгээр тушаал, А/41 дүгээр тушаалаар тус тус үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг сонгох ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. 2023 оны хагас жилийн байдлаар тус ажлын хэсэг нь 17 удаа хуралдаж алба хаагчдын ажлын ачааллыг харгалзан, мөн санамсаргүй сонголтын аргаар (random number picker) сонгож үнэлгээний хороог байгуулан ажилласан. Тайлант хугацаанд Нийслэлийн Засаг даргаас ирүүлсэн 11 захирамжийн 32 төсөл, арга хэмжээний 11 үнэлгээний хороо, бусад газраас албан хүсэлтээр ирүүлсэн 5 албан хүсэлтийн дагуу 52 төсөл, арга хэмжээний 5 үнэлгээний хороо, нийт 84 төсөл арга хэмжээний 16 үнэлгээний хороог байгуулан тушаалын төсөл боловсруулан ажилласан. Үнэлгээний хороо байгуулах дундаж хугацаа 2.1 хоног байна.

Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах 2 тушаал гарсныг төрлөөр нь авч үзвэл ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй шалтгаанаар 1, Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд үнэлгээний хороо үүсгэх үед АЗ гэрчилгээгүй улмаас үнэлгээний хорооны гишүүнээс чөлөөлсөн 1 тушаал гарсан байна. Тус газарт Үнэлгээний хорооны хөндлөнгийн гишүүнээр ажиллах 27 Төрийн бус байгууллагын гишүүн хүсэлт ирүүлснийг дата бүртгэлд нэгтгэн үнэлгээний хорооны гишүүнээр томилон ажиллаж байна.

Тус газрын хяналтад авсан нийт 39 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 2023 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар дараах хууль тогтоомж, тогтоол шийдвэр хяналтад байна.

Үүнд:

- Монгол Улсын 4 хууль;
- Ерөнхийлөгчийн 3 зарлиг;
- Засгийн газрын 10 тогтоол;
- Засгийн газар болон Ерөнхий сайдын 1 албан даалгавар;
- Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2 тогтоол;
- Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагаатай холбоотой 10 захирамж;
- Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 5 хуралдааны тэмдэглэл;
- Сангийн сайдын 1 тушаал;
- Монгол Улсын Эдийн засаг, Хөгжлийн сайдын 1 тушаал;
- Үндэсний аюулгүй байдлын 2 зөвлөмжийг 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор НЗДТГ-ын ХШҮХ-т хүргүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн 2023 оны эхний хагас жилийн байдлаар 14 хуралдаанаас тус газрын чиг үүрэгт хамааралтай 69 үүрэг даалгавар өгөгдсөнөөс дундаж хэрэгжилт 90,2 хувийн гүйцэтгэлтэй буюу “Бүрэн хэрэгжсэн” байна.

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын “Удирдлагын зөвлөлийн хурал” 11 удаагийн хуралдаанаас, 108 үүрэг даалгавар өгөгдсөн бөгөөд дундаж хэрэгжилт нь 86 хувийн гүйцэтгэлтэй буюу “Бүрэн хэрэгжсэн” байна.

Байгууллагын [www.ub-procurement.mn](http://www.ub-procurement.mn) цахим хуудаст үйл ажиллагаа, хүний нөөцийн бодлого, төсөв, санхүү, хууль эрх зүй, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны 35 мэдээллийг тухай бүр мэдээлж, ил тод байдлыг хангаж ажилласан.

## ЗУРГАА. ХУУЛЬ, ТОГТООМЖИД САНАЛ БОЛОВСРУУЛЖ ХҮРГҮҮЛСЭН БАЙДАЛ

1.НЗДТГ-ын 2023 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 06/328 дугаар албан бичгийн дагуу “Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэл, түүний сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийн төсөлд санал боловсруулан 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 4/218 дугаар албан бичгээр хариу хүргүүлсэн.

2.НЗДТГ-ын 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 06/745 дугаар албан бичгийн дагуу “Төрийн хэмнэлтийн тухай” хуулийн төсөлд санал боловсруулан 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 4/292 дугаар албан бичгээр хариу хүргүүлсэн.

3.НЗДТГ-ын 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 03/826 дугаар албан бичгийн дагуу “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ын төслийг боловсруулан 2023 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 4/426 дугаар албан бичгээр хариу хүргүүлсэн.

4.НЗДТГ-ын 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 03/2668 дугаар албан бичгийн дагуу “Хот, суурин газрын ногоон байгууламжийн тухай” хуулийн төсөлд санал боловсруулан 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 4/822 дугаар албан бичгээр хариу хүргүүлсэн.

5.НЗДТГ-ын 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 11/2619 дугаар албан бичгийн дагуу “Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар өөрчлөлт оруулах шаардлагатай захиргааны актын судалгаа”-г гаргаж 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 4/827 дугаар албан бичгээр хариу хүргүүлсэн.

6.“Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт”-ийн төсөлтэй танилцаж Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын албанд 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 4/875 дугаар албан бичгийн дагуу тус хуулийн төслийн саналыг нэгтгэн хүргүүлсэн.

ТАНИЛЦСАН:  
ДАРГА

Г.ЭНХТАЙВАН

ХЯНАСАН:  
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Б.ОЮУН-ЭРДЭНЭ

ТАЙЛАН ГАРГАСАН:  
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
МЭРГЭЖИЛТЭН

М.НОМИН-ЭРДЭНЭ

